

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /1/ НА-СТА-ТЕЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас:70353088 Цахим хаяг:orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас:70355805 Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас:70350757 Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан тайлан .....	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга .....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	12
3.5.2 Авлага.....	14
3.5.3 Урьдчилгаа.....	15
3.5.4 Бараа материал.....	15
3.5.5 Нөөцийн бараа .....	16
3.5.6 Үндсэн хөрөнгө .....	17
3.5.7 Өр төлбөр.....	18
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо .....	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	21
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	22
3.8 Аудитын гол асуудал .....	22
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	22
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
4. Аудитын илрүүлэлт.....	24
4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчил.....	24
4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа зөрчил .....	25
4.2.1 Залруулга .....	25
4.2.2 Зөвлөмж .....	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	27

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СНББХ	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ДТС	Дулаан түгээх сүлжээ
БОАЖГ	Байгал орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НҮА	Нийтлэг үйлчилгээний алба
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
УОО	Урьдчилж орсон орлого
ТАХОСС	Төрийн албан хаагчийн орон сууцны сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УТТО	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.04.06 № 112

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
С.БАТЖАРГАЛ ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>54,731,030.0</b>	<b>60,156,921.8</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	32,725,470.8	33,196,658.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	15,253,214.2	19,515,179.7
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	6,680,097.2	7,415,083.8
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	69,547.8	30,000.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>283,610,754.2</b>	<b>321,438,913.8</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	100,000.0	100,000.0
37200	Үнэт цаас		100,000.0	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	283,510,754.2	321,338,913.8
39200	Биет хөрөнгө		256,604,772.6	295,410,610.7
39300	Биет бус хөрөнгө	13	26,905,981.7	25,928,303.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>338,341,784.2</b>	<b>381,595,835.6</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>38,497,749.3</b>	<b>37,353,114.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	25,648,759.8	24,839,354.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	36,744.5	0.0
41300	Өглөг	17а, 17б	15,806,999.5	22,566,577.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	9,805,015.9	2,272,776.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,848,989.5	12,513,760.2
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	12,848,989.5	12,513,760.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>299,844,034.9</b>	<b>344,242,721.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		299,844,034.9	344,242,721.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		72,275,996.4	66,865,003.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		12,878,327.5	16,145,725.1
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		39,254,648.9	43,306,708.4
51200	Хуримтлагдсан үр дүн		93,850,466.0	136,920,465.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		81,584,596.1	81,004,819.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>338,341,784.2</b>	<b>381,595,835.6</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>154,115,159.3</b>	<b>187,851,083.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>71,077,915.9</b>	<b>78,263,858.3</b>
110	Орлогын албан татвар		40,095,409.9	42,252,992.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		42,079,411.0	44,663,814.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,984,001.1	-2,410,822.2
113	Хөрөнгийн албан татвар		9,511,375.1	13,038,898.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		21,471,131.0	22,971,967.8
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	<b>77,028,627.3</b>	<b>96,119,342.5</b>
120	Нийтлэг татварын бус орлого		29,156,222.2	47,744,764.2
122	Тусламжийн орлого		382,177.4	839,933.0

123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		47,490,227.7	47,534,645.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>6,008,616.1</b>	<b>13,467,883.1</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	<b>130,169,101.1</b>	<b>124,890,427.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>130,169,101.1</b>	<b>124,890,427.3</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		96,281,822.5	96,744,766.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		40,695,367.7	41,560,897.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,193,474.4	5,524,757.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,311,578.0	2,601,701.6
2104	Хангамж, бараа материалын зардал		3,311,309.8	3,262,418.3
2105	Нормативт зардал		2,591,307.4	1,051,335.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		875,074.2	1,919,135.6
2107	Томилолт, зочны зардал		142,551.2	150,523.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		22,400,005.9	18,294,407.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		18,761,153.7	22,379,590.3
212	ТАТААС		1,127,898.3	1,030,857.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,759,380.3	27,114,802.8
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>23,946,058.2</b>	<b>62,960,656.6</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		<b>161,700.8</b>	<b>0.0</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>31,007,567.2</b>	<b>20,926,258.3</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>		<b>-6,899,808.1</b>	<b>42,034,398.4</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>302,709,610.5</b>	<b>0.0</b>	<b>302,709,610.5</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,390.9	0.0	7,390.9
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>302,717,001.4</b>	<b>0.0</b>	<b>302,717,001.4</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	326,900.0	0.0	326,900.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	117,886.0	0.0	117,886.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	3,582,055.6	0.0	3,582,055.6
9	Тайлант үеийн үр дүн	-6,899,808.1	0.0	-6,899,808.1
<b>10</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>299,844,034.9</b>	<b>0.0</b>	<b>299,844,034.9</b>
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>299,844,034.9</b>	<b>0.0</b>	<b>299,844,034.9</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,035,601.2	0.0	1,035,601.2
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>300,879,636.1</b>	<b>0.0</b>	<b>300,879,636.1</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-579,776.9	0.0	-579,776.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	841,498.4	0.0	841,498.4
17	Өмчид гарсан өөрчилөлт	1,066,965.4	0.0	1,066,965.4
19	Тайлант үеийн үр дүн	42,034,398.4	0.0	42,034,398.4
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>344,242,721.4</b>	<b>0.0</b>	<b>344,242,721.4</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>166,188,046.5</b>	<b>173,655,407.0</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>71,077,915.9</b>	<b>78,263,858.3</b>
110	Орлогын албан татвар		40,095,409.9	42,252,992.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		42,079,411.0	44,663,814.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,984,001.1	-2,410,822.2
113	Хөрөнгийн албан татвар		9,511,375.1	13,038,898.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		21,471,131.0	22,971,967.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		1,653,445.1	3,108,365.8
1181	Газрын төлбөр		19,461,396.5	19,483,775.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		356,289.4	379,827.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>87,276,556.5</b>	<b>80,514,098.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого		39,786,328.8	32,979,453.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		47,490,227.7	47,534,645.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>7,833,574.0</b>	<b>14,877,450.1</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>132,804,131.5</b>	<b>133,690,945.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>132,804,131.5</b>	<b>133,690,945.8</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		98,876,267.4	105,483,154.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		44,369,979.3	45,304,453.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,315,419.8	6,572,565.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,059,910.1	3,027,988.7
2104	Хангамж, бараа материалын зардал		3,748,254.9	3,574,700.7
2105	Нормативт зардал		2,573,434.1	961,605.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		808,180.9	1,022,100.9
2107	Томилолт, зочны зардал		135,278.2	148,949.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,612,751.2	34,249,663.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		6,253,058.9	10,621,127.5
212	ТАТААС		1,127,898.3	1,030,857.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,799,965.7	27,176,934.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>33,383,915.0</b>	<b>39,964,461.2</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		<b>42,433.8</b>	<b>12,500.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>29,363,780.0</b>	<b>39,352,472.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>29,363,780.0</b>	<b>39,352,472.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр		29,363,780.0	39,352,472.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>		<b>-29,321,346.2</b>	<b>-39,339,972.0</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>		<b>-378,156.6</b>	<b>-153,301.7</b>
14	Бусад эх үүсвэр		0.0	501,408.7
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>		<b>378,156.6</b>	<b>401,590.0</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		<b>0.0</b>	<b>253,120.4</b>

<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		<b>3,684,412.2</b>	<b>471,187.5</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		29,041,058.7	32,725,470.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		32,725,470.8	33,196,658.3

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>145,678,669.5</b>	<b>129,079,633.7</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	109,290,540.4	98,563,335.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,481,361.9	70,977,840.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,074,228.7	40,683,036.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,503,459.7	5,399,467.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,776,689.4	2,593,813.5
Хангамж, бараа материалын зардал	1,844,278.4	1,814,109.6
Нормативт зардал	914,881.9	896,688.1
Эд хогшил, урсгал засварын зардал	753,899.8	748,047.0
Томилолт, зочны зардал	174,316.0	143,074.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,524,452.4	14,879,917.3
Бараа үйлчилгээний бусад зардал	3,915,155.6	3,819,686.3
ТАТААС	1,200,000.0	1,030,857.6
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,200,000.0	1,030,857.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,609,178.5	26,554,637.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,776,615.1	24,776,615.1
Бусад урсгал шилжүүлэг	1,832,563.4	1,778,022.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,809,343.5	30,114,708.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	578,785.6	401,590.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>145,678,669.5</b>	<b>125,652,282.0</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,534,645.4	47,337,707.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,273,795.3	76,331,341.8
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	29,907.5	30,024.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,840,321.3	1,953,208.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,004,258.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,576,906.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.1	0.1
АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.3	3.3
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	26.0	26.3
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	19.4	20.1
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6.5	6.2
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.0	0.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3.3	3.3

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,929,912.2</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,735,234.0</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,222,435.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,337.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,837.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,828.8
Хангамж, бараа материалын зардал	417,671.5
Нормативт зардал	62,512.8
Эд хогшил, урсгал засварын зардал	379,101.6
Томилолт, зочны зардал	4,453.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,480,395.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,997,296.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	512,798.5
Бусад урсгал шилжүүлэг	243,426.7
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	269,371.9
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>194,678.2</b>
Дотоод эх үүсвэрээр	194,678.2
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,940,191.8</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,940,191.8
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,279.6

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 01/783 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах нь манай аймгийн эрхэм зорилго мөн”, “аймгийн удирдлага нь иргэддээ орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх алсын хараатай ажиллана” гэж тодорхойлсон байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.  
Үүнд:

- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн”, 60.1-д “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн” гэж заасан бөгөөд нийт 21 бүрэн эрхийг тусгасан байна.
- Төсвийн тухай хуулийн 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”
- Төсвийн тухай хуулийн 54.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж Орхон аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/557 дугаар захирамжаар баталсан байна. Уг НБББББ-г нэгтгэлд хамрагддаг байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлээгүй нь санхүүгийн тайланг бэлтгэх ба толилуулахад баримтлах зарчим, нэгтгэлд хамрагдах байгууллагуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг нэг журам, заавар, аргачлалаар бэлтгэхгүй, хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт нь харилцан адилгүй байх санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг үр дагавартай байна.

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Орхон аймгийн ТЕЗ-ын Санхүүгийн хяналт, аудитын албыг Сангийн яамнаас стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Орхон аймгийн СХАА нь хяналт шалгалтын төлөвлөгөөгөө аймгийн Засаг дарга, дотоод аудитын хорооны даргаар батлуулсан ба 2021 он төлөвлөгөөт 61, төлөвлөгөөт бус 4, нийт 65 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн байна.

Эдгээр хяналт шалгалтаар 1,524.1 сая төгрөгийн зөрчил арилгуулах 73 албан шаардлага, 251 зөвлөмж хүргүүлэн, 35.9 сая төгрөгийн 39 нөхөн төлбөрийн акт тогтоосон ба үүнээс 1,374.8 сая төгрөгийн 65 албан шаардлагын биелэлтийг гаргуулж, 29.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийн актын биелэлт хангагдсан байна. Мөн өмнөх онуудын төлөгдөөгүй актын үлдэгдэл 0.3 сая төгрөгийн биелэлт хангагдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг тохируулсан аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 381,596.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,816.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,671.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшнийг 2021 оны залруулсан санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 381,595.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 3,815.9 сая төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,254.0 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар нэмэгджээ.

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 33,196.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувь буюу 460.9 сая төгрөгөөр өссөн байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2021 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.8</b>	<b>0.0</b>	<b>0.1</b>	<b>0.0</b>	<b>-0.6</b>	<b>0.0</b>
Төгрөг	0.8	0.0	0.1	0.0	-0.6	0.0
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>32,724.7</b>	<b>100.0</b>	<b>33,196.5</b>	<b>100.0</b>	<b>461.6</b>	<b>1.4</b>
Төгрөг	32,724.7	100.0	33,196.5	100.0	461.6	1.4
- Төрийн сангийн харилцах	32,074.5	98.0	31,761.6	95.7	-312.9	-1.0
- Арилжааны банк дахь харилцах	650.2	2.0	1,424.7	4.3	774.4	2.4
- Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.0	0.0	10.3	0.0		
<b>Нийт дүн</b>	<b>32,725.5</b>	<b>100.0</b>	<b>33,196.7</b>	<b>100.0</b>	<b>460.9</b>	<b>1.4</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		Үүнээс:		
		Дүн	Хувь	Касс	Төрийн сан	Арилжааны банк
- Төсөвт байгууллага	16,632.1	12,395.4	37.3	0.1	12,362.7	32.6
- Төрийн сан	15,583.6	19,409.1	58.5		19,409.1	
- Төсөл сан	0.0	0.0	0.0			
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	509.7	1,392.1	4.2	0.0		1,392.1
<b>Нийт дүн</b>	<b>32,725.5</b>	<b>33,196.7</b>	<b>100.0</b>	<b>0.1</b>	<b>31,771.9</b>	<b>1,424.7</b>

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкин дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл 1.4 хувь буюу 461.6 сая төгрөгөөр өсөж, кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 0.6 сая төгрөгөөр буурсан байна. Төрийн сангийн болон төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө 411.2 сая төгрөгөөр буурч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн мөнгөн хөрөнгө 882.4 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 4.2 хувийг ОНӨААН, 58.5 хувийг төрийн сан, 37.3 хувийг төсвийн байгууллагууд бүрдүүлж байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл банканд байгаа бэлэн мөнгөнөөс бүрдэж байна. Үүний 95.7 хувь нь төрийн сангийн харилцах, 4.3 хувь нь арилжааны банкны харилцах байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал төрийн сангийн мөнгөн хөрөнгө 3,825.5 сая төгрөгөөр, ОНӨААН-ийнх 882.4 сая төгрөгөөр тус тус өссөн, төсөвт байгууллагынх 4,236.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тайлант оны мөнгөн хөрөнгийн өсөлт нь ОНӨО-ын дансны өсөлт, барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын дансны өсөлт бол төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн бууралт нь Орхон аймаг болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2020 онд Эрдэнэт санд олгосон санхүүжилтээс тайланд онд ажлын гүйцэтгэл гараагүй үлдсэн 4,246.9 сая төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын СББХ-ийн 2021.12.16-ны өдрийн 111/414 тоот албан бичгийн дагуу буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бөгөөд өмнөх оны зөвлөмжийн хүрээнд төрийн сангийн төрийн банкин дахь дансны үлдэгдэл 108.5 сая төгрөгийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж уг дансыг хаасан байна.

### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>15,583.6</b>	<b>100.0</b>	<b>19,409.1</b>	<b>100.0</b>	<b>3,825.5</b>	<b>24.5</b>
<i>Төгрөг</i>	15,583.6	100.0	19,409.1	100.0	3,825.5	24.5
- Төрийн сангийн харилцах	15,475.1	99.3	19,409.1	100.0	3,934.0	25.2
- Арилжааны банк дахь харилцах	108.5	0.7		0.0	-108.5	-0.7
<b>Нийт дүн</b>	<b>15,583.6</b>	<b>100.0</b>	<b>19,409.1</b>	<b>100.0</b>	<b>3,825.5</b>	<b>24.5</b>

Эх сурвалж: Орхон аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсөвт татварын орлогоор 78,263.9 сая төгрөг бүрдүүлж, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын цэвэр санхүүжилтэд 2,151.1 сая төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал санхүүжилтэд 50,583.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 23,375.4 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант онд ОНӨО-н дансанд татварын бус орлого буюу торгуулийн орлогоор 1,755.2 сая төгрөг, бусад орлогоор 171.5 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн, бүртгэл, тайлагнал, баталгаажуулалт, санхүүгийн сахилга, хариуцлага, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 1,112.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 23.5 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 40.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 652.6 сая төгрөгийн албан шаардлага, 396.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн.

### 3.5.2 Авлага

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 15,253.2 сая төгрөг байснаас тайлант онд 4,262.0 сая төгрөгөөр буюу 27.9 хувиар өсөж, оны эцэст 19,515.2 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Ажиллагчидтай холбогдсон авлага	34.0	0.2	33.4	0.2	-0.6	0.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,978.7	13.0	572.8	2.9	-1,406.0	-9.2
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	70.7	0.4	70.7	0.5
Дансны авлага /ТӨҮГ/	0.0	0.0	15.2	0.1	15.2	0.1
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	16.0	0.1	5.5	0.0	-10.5	-0.1
Байгууллагаас авах авлага	11,977.5	78.5	17,592.4	90.1	5,614.9	36.8
Хувь хүмүүсээс авах авлага	466.4	3.1	459.7	2.4	-6.7	0.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	615.0	4.0	615.0	3.2	0.0	0.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	165.5	1.1	150.5	0.8	-15.0	-0.1
<b>Нийт дүн</b>	<b>15,253.2</b>	<b>100.0</b>	<b>19,515.2</b>	<b>100.0</b>	<b>4,262.0</b>	<b>27.9</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	1,676.2	11.0	2,162.2	11.1	486.0	3.2
- Төрийн сан	744.7	4.9	744.7	3.8	0.0	0.0
- Төсөл сан	220.9	1.4	216.0	1.1	-4.9	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	12,611.5	82.7	16,392.3	84.0	3,780.8	24.8
<b>Нийт дүн</b>	<b>15,253.2</b>	<b>100.0</b>	<b>19,515.2</b>	<b>100.0</b>	<b>4,262.0</b>	<b>27.9</b>

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс нийт авлагын эцсийн үлдэгдлийн 0.2 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага, 2.9 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 0.4 хувийг татаас санхүүжилтийн авлага, 0.1 хувийг дансны авлага /ТӨҮГ/, 90.1 хувийг байгууллагаас авах авлага, 2.4 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 3.2 хувийг засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл, 0.8 хувийг хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл тус тус бүрдүүлж байна.

Байгууллагаас авах авлага 5,614.9 сая төгрөг буюу 36.8 хувиар нэмэгдэж өмнөх онд нийт авлагын 78.5 хувийг эзэлж байсан бол тайлант онд 90.1 хувийг эзэлж байна.

Байгууллагаас авах авлагын өсөлт нь орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдтэй холбоотой бөгөөд ихэнх хувь нь Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн авлага байна.

Байгууллагын төрлөөр харвал авлагын эцсийн үлдэгдлийн 84.0 хувь буюу 16,392.3 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн авлага, 11.1 хувь буюу 2,162.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын авлага, 3.8 хувь буюу 744.7 сая төгрөгийг төрийн сангийн авлага, 1.1 хувь буюу 216.0 сая төгрөгийг төсөл сангийн авлага тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага 3.2 хувь буюу 486.0 сая төгрөгөөр, ОНӨААН-ийн авлага 24.8 хувиар буюу 3,780.8 сая төгрөгөөр тус тус өссөн, төсөл сангийн авлага 4.9 сая төгрөгөөр буурсан байна. Авлагын ангиллаар авч үзвэл эдгээр нь ихэвчлэн байгууллагаас авах авлага болжээ.

Тайлант онд ӨЭМТ-үүдийн авлага 583.7 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь Эрүүл мэндийн даатгалын санхүүжилттэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн актгүй болон насжилт өндөртэй, бүрэн барагдахгүй, цаашид шийдвэрлэгдэхгүй байх үр дагавартай авлага оршин байна. Тухайлбал:

- 1996-1997 онуудад дампуурсан ХОТШ, даатгал банктай холбоотой орон нутгийн 9 байгууллагын 134.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна.
- Их шүтээн цогцолборын 68.6 сая төгрөгийн он дамжсан авлага.

Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд арилжааны 3 банканд 615.0 сая төгрөгийн зээлийн авлага байна. Энэхүү зээл нь байнгын эргэлтэд ашиглагдаж байна.

ТЕЗ-ийн хоорондын тооцоотой холбоотой авлага, өр төлбөрийн 57.0 сая төгрөгийг устгах бичилт хийсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой НББ-ийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг хугацаанд нь барагдуулаагүй, хууль тогтоомж хэрэгжүүлээгүй зэрэг нийт 406.8 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 95.4 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 12.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 275.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, 22.8 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.5.3 Урьдчилгаа

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2.7 сая төгрөг байснаас тайлант онд буурч, оны эцэст үлдэгдэлгүй тайлагнасан байна.

### 3.5.4 Бараа материал

Орхон аймгийн ТЕЗ-ийн бараа материалын дансны эхний үлдэгдэл 6,680.1 сая төгрөг байснаас 735.0 сая төгрөгөөр өсөж, 7,415.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын үлдэгдлийг ангилал, байгууллагын төрлөөр харуулбал:

**Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл**

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Түүхий эд материал</b>	<b>4,834.6</b>	<b>72.4</b>	<b>5,133.5</b>	<b>69.2</b>	<b>298.9</b>	<b>4.5</b>
- Тусгай зориулалттай материал	4,720.2	70.7	4,737.6	63.9	17.4	0.3
- Эм боох материал	114.4	1.7	395.9	5.3	281.5	4.2
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>5.8</b>	<b>0.1</b>	<b>5.6</b>	<b>0.1</b>	<b>-0.2</b>	<b>0.0</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>1,783.1</b>	<b>26.7</b>	<b>2,168.6</b>	<b>29.2</b>	<b>385.5</b>	<b>5.8</b>
- Бичиг хэргийн материал	97.5	1.5	106.8	1.4	9.3	0.1

- Аж ахуйн материал	574.1	8.6	662.8	8.9	88.7	1.3
- Сэлбэг хэрэгсэл	34.7	0.5	50.1	0.7	15.5	0.2
- Түлш, шатах тослох материал	56.9	0.9	35.8	0.5	-21.2	-0.3
- Барилгын засварын материал	113.2	1.7	418.7	5.6	305.5	4.6
- Хүнсний материал	36.6	0.5	16.4	0.2	-20.3	-0.3
- Бусад хангамжийн материал	870.1	13.0	878.0	11.8	8.0	0.1
<b>Мал амьтад</b>	<b>56.6</b>	<b>0.8</b>	<b>107.4</b>	<b>1.4</b>	<b>50.8</b>	<b>0.8</b>
<b>Нийт дүн</b>	<b>6,680.1</b>	<b>100.0</b>	<b>7,415.1</b>	<b>100.0</b>	<b>735.0</b>	<b>11.0</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	5,918.1	87.0	6,581.6	88.8	663.6	9.9
- Төрийн сан		0.0		0.0	0.0	0.0
- Төсөл сан		0.0		0.0	0.0	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	762.0	13.0	833.5	11.2	71.4	1.1
<b>Нийт дүн</b>	<b>6,680.1</b>	<b>100.0</b>	<b>7,415.1</b>	<b>100.0</b>	<b>735.0</b>	<b>11.0</b>

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 11.2 хувь буюу 833.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит ААН, 88.8 хувь буюу 6,581.6 сая төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна.

Тайлант оны бараа материалын өсөлтөд түүхий эд материал 4.5 хувиар буюу 298.9 сая төгрөгөөр, хангамжийн материал 385.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Энэ нь эм боох материал, аж ахуйн материал, барилгын засварын материалын өсөлт байна.

Тайлант онд нийт 14,418.8 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдан авсан 9,072.5 сая төгрөг, хандив, тусламжаар хүлээн авсан 2,824.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 1,072.9 сая төгрөг, бусад хэлбэрээр хүлээн авсан 1,449.1 сая төгрөг байна. Харин нийт 13,683.8 сая төгрөгийн бараа материал хасагдсаны 13,065.3 сая төгрөгийг худалдан зарцуулсан, 75.4 сая төгрөгийг шилжүүлсэн, 543.1 сая төгрөгийг бусад хэлбэрээр зарлагдсан байна.

Үүнээс ОНӨААН-үүд тайлант онд нийт 1,353.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,431.1 сая төгрөгийн бараа материал худалдан, зарцуулсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлогоор тусгахгүй шууд зардлаар бүртгэсэн, бараа материалын нэр төрлийн хөдөлгөөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй, тушаал шийдвэргүй данс бүртгэлээс хассан, зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг нийт 224.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 48.5 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 121.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, 52.1 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.5.5 Нөөцийн бараа

Орхон аймгийн ТЕЗ-ийн нөөцийн барааны эхний үлдэгдэл 69.5 сая төгрөг байснаас 39.5 сая төгрөгөөр буурч, 30.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь өвс, тэжээлийн нөөц байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Орхон аймгийн ТЕЗ-ийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 283,510.8 сая төгрөг байснаас 13.3 хувиар буюу 37,828.2 сая төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 321,338.9 сая төгрөг болсон байна.

Нийт хөрөнгийн 91.9 хувийг биет хөрөнгө, 8.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Биет хөрөнгө</b>	<b>256,604.8</b>	<b>90.5</b>	<b>295,410.6</b>	<b>91.9</b>	<b>38,805.8</b>	<b>13.7</b>
Барилга, байгууламж	168,065.4	59.3	174,287.8	54.2	6,222.4	2.2
Авто тээврийн хэрэгсэл	2,587.5	0.9	2,258.0	0.7	-329.6	-0.1
Машин тоног төхөөрөмж	13,950.8	4.9	15,319.0	4.8	1,368.2	0.5
Тавилга эд хогшил	3,051.3	1.1	3,015.9	0.9	-35.4	0.0
Зам, гүүрийн байгууламж	19,057.7	6.7	22,388.4	7.0	3,330.7	1.2
Түүх, соёл, музейн дурсгалт зүйлс	692.9	0.2	693.2	0.2	0.4	0.0
Бусад үндсэн хөрөнгө	19,673.2	6.9	22,410.2	7.0	2,737.0	1.0
Дуусаагүй барилга	29,224.7	10.3	54,725.6	17.0	25,500.9	9.0
Ном	301.2	0.1	312.5	0.1	11.3	0.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>26,906.0</b>	<b>9.5</b>	<b>25,928.3</b>	<b>8.1</b>	<b>-977.7</b>	<b>-0.3</b>
Программ хангамж	376.0	0.1	366.1	0.1	-9.9	0.0
Бусад биет бус хөрөнгө	26,530.0	9.4	25,562.2	8.0	-967.8	-0.3
